

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
оны 04 сарын 25 өдрийн
албан бичгийн хавсралт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2023 оны 4 дугаар сарын 25-ны өдөр

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	Тайлант хугацаанд манай байгууллагад 65.290,5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 52.628,6 мянган төгрөгийг зарцуулж 12.661,9 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулж, улирлын тайланг хугацаанд нь илгээсэн.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	3-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Сүмбэр сумын 2-р цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	4 сард	Сүмбэр сумын 2-р цэцэрлэгийн 2022-2023 оны засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ. Дотоод аудитаар тус байгууллагын үйл ажиллагааг "Сайжруулах шаардлагатай" гэсэн дүгнэлтийг өгсөн. Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үнэлэгдэв. Шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд 10 зөвлөмж өгсөн.
3	Баянтал сумын ЗДТГазрын 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	4 сард	Баянтал сумын ЗДТГазрын 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Нэгдсэн удирдамжтай шалгалт хийж байгаатай холбогдуулан шалгалтыг түр хойшлуулсан.
4	Сангийн сайдын баталсан нэгдсэн удирдамжаар санхүүгийн	Санхүүгийн сахилга бат сайжирна	4 сард	Сангийн сайдын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдөр баталсан СХШХ/02 дугаартай удирдамж, аймгийн Засаг даргын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 05 дугаартай батлагдсан удирдамжаар Нийгмийн даатгалын

	хяналт шалгалт хийх			хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаа болон 4 сангуудын 2021, 2022 оны баримтанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 95 хувьтай. Шалгалтын дүнг нэгтгэж байна
6	Шивээговь сумын 3-р цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	4 сард	Шивээговь сумын 3-р цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна. Ажлын явц 70 хувь.
7	Сүмбэр сумын ЗДТГ-ын 2021-2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	4 сард	Сүмбэр сумын ЗДТГ-ын 2021-2022 он, 2023 оны 1,2 дугаар сарын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж байна. Нэгдсэн удирдамжтай шалгалт хийж байгаатай холбогдуулан шалгалтыг түр хойшлуулсан.
8	Шивээговь сумын ЗДТГ-ын 2022-2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна	4 сард	Шивээговь сумын ЗДТГ-ын 2022-2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж байна. Нэгдсэн удирдамжтай шалгалт хийж байгаатай холбогдуулан шалгалтыг түр хойшлуулсан.
9	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах	4 сард	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 1 дүгээр улирлын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 94.1 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 1.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд нийт 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 13 мэдээллийг огт мэдээлээгүй. Үүнд: Сүмбэр сумын 2 дугаар сургууль 13 мэдээлэл оруулаагүй, Баянтал сумын Эрүүл мэндийн төв 8, Баянтал сумын 4 дүгээр сургууль 5, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг 2, Аймгийн халамжийн сан 1 нийт 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлжээ.
10	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	4 сард	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 5 мэдээ байршуулан

				байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчилж байна.
11	Хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хяналт шалгалт үр дүн сайжирна, зөрчил буурна	4 сард	Тайлант хугацаанд төлөвлөгөөт бус 2 хяналт шалгалт хийж нийт 20.323,3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 18.971,3 мянган төгрөгийн зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлж, 552,0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоон, 800,0 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Акт, нөхөн төлбөр, албан шаардлагыг биелүүлэх хугацаа дуусаагүй байна. Өнгөрсөн оны актын төлбөрөөс орон нутгийн орлогын 100220000982 тоот дансанд 1.190,1 мянган төгрөгийг төлүүлсэн.
12	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	4 сард	Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 4үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагддаг “7:4:10” вебинар сургалтад 7хоног бүрийн Пүрэв гараигт албан хаагчид бүрэн хамрагдаж байна. Тайлант хугацаанд дараахь сэдвээр сургалт зохион байгуулагдсан байна. Үүнд. 1.“Үндсэн хуулийн үзэл баримтлал”-III/30 2. “Стрессийг зохицуулахад таны оролцоо”-IV/6 3.“Цахим шилжилт”-IV/13 4.“Бүтээмж нэмэгдүүлэх нь”-IV/20 “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн бүсчилсэн сургалт” Дорноговь аймгийн Сайншанд суманд 2023.03.31-2023.04.01 өдрүүдэд зохион байгуулагдсан сургалтад Дотоод аудитор Л.Эрдэнэчимэг оролцсон. 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Биеийн тамир спортын газар, Эрүүл мэндийн газраас хамтран зохион байгуулсан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй албан байгууллага аж ахуйн нэгж дахь биеийн тамир хариуцсан арга зүйчдийн эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл чийрэг бие бялдар, биеийн жингийн зохистой харьцаанд анхаарах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, Түмэн дасгалыг танилцуулах сургалтад нягтлан бодогч Б.Аззаяа хамрагдсан. 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Боловсрол шинжлэх ухааны яам, аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран зохион

			байгуулсан Монгол хэлний тухай хууль, Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулахтай холбогдуулан төрийн байгууллагуудын холбогдох албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, цахим бичвэр боловсруулах арга аргачлалд сургалтад бичиг хэргийн ажилтан Б.Аззаяа хамрагдлаа. 2023 оны 4-р сарын 5,6-ны өдрүүдэд Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тотоох тухай журам”-ын хэрэгжилтийг шинэчлэгдсэн шилэн дансны мэдээллийн санд хэрхэн оруулах тухай мэргэжил аргазүйн сургалт зөвлөгөөг Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын ЗДТГ-ын санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, мэргэжилтэн, ерөнхий санхүүч нарт зохион байгууллаа. Мөн шинэ шилэн дансны мэдээллийн санд хэрхэн оруулах тухай мэргэжил аргазүйн сургалт, зөвлөгөөг дараах байгууллагын санхүүч нар өгч ажилласан болно. Үүнд: - Илчлэг шивээ ОНӨААТҮГ-III/29 - -1-р цэцэрлэг- III/30 - Шивээговь ЭМТ, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар-IV/06 - Байгаль орчин аялал жуулчлалын газар, Боржигин өв музей—IV/07 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Засгийн Газраас санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэгт 2 албан хаагч хамрагдсан
--	--	--	--

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:  Л.Эрдэнэчимэг